


### Хувьцааны арилжааны мэдээлэл

2023 оны 9-р сарын 1	MSE: SUU
Хаалтын ханш (2023.09.01):	₮ 390.52
52 долоо хоног:	₮ 366.00-504.00
Нийт гаргасан тоо ширхэг:	344,000,000
Зах зээлийн үнэлгээ:	₮ 133,972,538,655.28

### ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ТҮҮХ

Эх сурвалж: МХБ



### ГОЛЛОХ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД\*

Үнэ-ашгийн харьцаа (P/E)	9.55
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	2.87
Үнэ-борлуулалтын харьцаа (P/S)	1.04
Ноогдол ашгийн өгөөж	2.59%

Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Эх сурвалж: МХБ



## КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

1958 онд Сүүний үйлдвэр нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн Монголын ууган сүүний үйдвэрлэгч болох Сүү ХК нь 1990-ээд оны эхээр төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болсон ажээ. Үүнээс 15 гаруй жилийн дараа буюу 2015 онд бүрэн хувьчлагдан одоогоор бүтэцдээ 14 хоршоо, 2500 бэлтгэн нийлүүлэгчтэй Монгол Улсын хэмжээнд үйдвэрийн аргаар боловсруулсан шингэн сүүний зах зээлийн 61 хувийг эзэлдгээрээ онцлог томоохон аж ахуйн нэгж юм.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

СҮҮ ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдээр хувьд ТУЗ-ын гишүүд болох Дагвадоржийн Жамъян, Дондовцэрэнгийн Уянгальянхуа болон ТУЗ-ын дарга Дагвадоржийн Ганбаатар нар тус тус 38.80%, 33.15% болон 21.06%-ийг эзэмшдэг. Тус компани нийт 344 сая хувьцаа гаргаснаас 99.73 хувь нь нээлттэй арилжаалагддаг байна.

## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сүү ХК нь 2022 оны байдлаар нийт 550 ажилтантай үйл ажиллагаа явуулж улсын хэмжээнд үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан шингэн сүүний зах зээлийн 61 хувийг эзэлж байна. Тус компани хоногт 200 тонн сүү хүлээн авч 150 тонн сүү, тараг боловсруулах хүчин чадалтай байна. 2022 онд СҮҮ ХК үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлсэн тул үндсэн хөрөнгийн дүн 57.02 хувиар өсөж сүү бэлтгэлийн төлөвлөгөө 124 хувиар биелэгдэн 9.7 сая литр хүрсэн байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар сүү тараг, зайрмаг болон аарцан бүтээгдэхүүний борлуулалт 14-39% өсөлтийг үзүүлсэн бол цөцгийн тосны борлуулалт 6 дахин нэмэгдсэн байна.

## БОРЛУУЛАЛТ

**СҮҮ:** Миний Монголын Сүү, Сүү Milk, Сайхан Сүү, Өтгөн Сүү, Шинэ Сүү

**ТАРАГ:** Гоофит тараг, Амтлаг тараг, Цөцгийтэй тараг, Миний Монголын элгэн тараг, BioFit болон Амтлаг тараг

**ЗАЙРМАГ:** Импортын зайрмагтай өрсөлдөхүйц хэмжээний Итали технологиор үйлдвэрлэгддэг “Amore” зайрмаг болон “Мөрөөдлийн” иштэй зайрмагны төрлүүд


**СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН:** Шар савлагатай 200 болон 500 граммаар савлагдсан цөцгийн тос, энгийн болон үзэмтэй аарц, хорхой ааруул, зөөхий болон амин уураг

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны хоёрдугаар улирлын байдлаар Сүү ХХК-ийн борлуулалтын орлого 73.52 тэрбум төгрөг хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулбал 37.81 хувийн өсөлтийг үзүүлсэн бол цэвэр ашиг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 180.08 хувь өсөж 8.86 тэрбум төгрөг хүрсэн байна. 2019-2022 оны хооронд компанийн борлуулалтын орлого жилд дунджаар 13.73 хувийн өсөлттэй байсан бол тус хугацааны турш цэвэр ашиг жилийн 13.72 хувийн өсөлтийг үзүүлсэн байна. Тус компанийн нийт хөрөнгийн хэмжээ 2023 оны 2-р улиралд 91.65 тэрбум төгрөг хүрч 2022 оны жилийн эцсийн үзүүлэлтээс 4.35 хувиар өссөн байна. 2022 оны цэвэр ашгаас СҮҮ ХК нийтдээ нэгж хувьцаанд 7.00 төгрөгийн ноогдол ашиг тараасан бол 2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 2,642,117,608.9 төгрөг /нэгж хувьцаанд тус бүр 7.7 төгрөг/ буюу 29.83 нь хувийг хувьцаа эзэмшигчдэд хувиарилахаар шийдвэрлэсэн байна.



Голлох харьцаа үзүүлэлтүүд\* - Хувьцааны ханшийг 2023 оны 9-р сарын 1-ний өдрийн хаалтын ханшаар, санхүүгийн үзүүлэлтийг 2023 оны 2-р улирлын тайлангаар болон жилчилсэн дүнгээр, ногдол ашгийн өгөөжийг 2022 оны үйл ажиллагааны үр дүнд үндэслэн тус тус тооцов.



Эх сурвалж: Голомт Банк ХК,  
Голомт Капитал ҮЦК тооцоолол